

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ “ЧАНДМАНЬ-БАЯНХОНГОР” ХК

-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: БНА-2019/10/-НА**

---

Баянхонгор хот 2019 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга**  
**бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

**Аудитын менежер Д.Цэцэгмаа**

Утас: 70442424 цахим хуудас: [tsetsegmaadam@audit.gov.mn](mailto:tsetsegmaadam@audit.gov.mn)

**Аудитор Б.Азбаяр**

Утас: 99061429 цахим хуудас: [azbayarb@audit.gov.mn](mailto:azbayarb@audit.gov.mn)

**Аудитор Н.Бунчинсүрэн**

Утас: 99049866 цахим хуудас: [nbunchin0719@gmail.com](mailto:nbunchin0719@gmail.com)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу

---

## Товчилсон үгийн тайлбар

|               |                                                                                    |
|---------------|------------------------------------------------------------------------------------|
| АДБОУС        | Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт                                   |
| ИТХ           | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                                                       |
| ҮАГ           | Үндэсний аудитын газар                                                             |
| ЗДТГ          | Засаг даргын Тамгын газар                                                          |
| ОНӨГ          | Орон нутгийн өмчийн газар                                                          |
| СТСХ          | Санхүү, төрийн сангийн хэлтэс                                                      |
| МХГ           | Мэргэжлийн хяналтын газар                                                          |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ХОХБТХ        | Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс                              |
| ХК            | Хувьцаат компани                                                                   |
| ХХК           | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                                               |

**Тайланг хянасан:**  
**Баянхонгор аймаг**  
**дахь Төрийн**  
**аудитын газар**

**Дарга, тэргүүлэх**  
**аудитор**  
**Б.Мөнхбат**

**Аудитын менежер**  
**Д.Цэцэгмаа**  
**Тайланг бэлтгэсэн:**  
**Ахлах аудитор**  
**Б.Азбаяр**

**Аудитор**  
**Н.Бүнчинсүрэн**

**2019 оны 06 дугаар**  
**сарын 20-ны өдөр**

**Уг тайланг ҮАГ-ын**  
**Цахим хуудаснаас**  
**үзнэ үү:**  
**[www.audit.mn](http://www.audit.mn)**

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70442424 дугаарын  
утас, 70442584  
дугаарын факсаар  
харилцана уу.

**ХАЯГ:**  
**Баянхонгор аймаг дахь**  
**Төрийн аудитын газар**  
**Аймгийн ЗДТГ-ын байр,**  
**Баянхонгор сум,**  
**Баянхонгор аймаг-**  
**64000**  
**Монгол Улс**

## АГУУЛГА

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Товчилсон үгийн тайлбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | 2  |
| НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | 4  |
| Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:                                                                                                                                                                                                                                                                                                                                       | 4  |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ                                                                                                                                                                                                                                                                                                                                          | 4  |
| Аудитын арга зүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | 4  |
| Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд                                                                                                                                                                                                                                                                                                                   | 4  |
| Үндсэн мэдээлэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 5  |
| НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | 6  |
| БҮЛЭГ 1.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | 6  |
| 1.1.Цэвэр усан хангамж, ариутгах татуургыг хөгжүүлэх бодлогыг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгаж хэрэгжилтийг тооцож ажилласан байна.                                                                                                                                                                                                                         | 6  |
| 1.2. “Чандмань-Баянхонгор” ХК нь хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэр гарч, дүрмийг өөрчлөн улсын бүртгэлд бүртгүүлсэн хэдий ч хуульд заасан шаардлагын дагуу үнэт цаасаа бүртгүүлээгүй, компанийн дүрмийг баримталж ажиллаагүй байна.                                                                                                     | 8  |
| БҮЛЭГ 2.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | 12 |
| 2.1. Компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа үндэслэл муутай төлөвлөснөөс орлогын төлөвлөгөө тасрах, батлагдаагүй зардал гаргасан нь алдагдалтай ажиллах шалтгаан болсон байна.                                                                                                                                                                                    | 12 |
| 2.2. Борлуулалтын орлогыг тайлагнахдаа зарим орлогыг орхигдуулж тайлагнасан байна.                                                                                                                                                                                                                                                                                      | 16 |
| Техникийн нөхцөл олгох үнэ тарифыг 2015 оны 06 дугаар сарын 12 –ний өдрийн захирлын тушаалаар цэвэр бохир усны техникийн нөхцөлийг 220.0 мянган төгрөгөөр дулааны техникийн нөхцөлийг 440.0 мянган төгрөгөөр, 2017 оны 06-р сарын 27-ноос Цэвэр бохир усны техникийн нөхцөлийг 500,0 мянга, дулааны техникийн нөхцөлийг 550,0 мянган төгрөгөөр тус тус тогтоосон байна. | 17 |
| 2.3. Компанийн гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс батлагдсан зардлыг баримталж ажиллаагүйгээс зарим төрлийн зардал хэтэрсэн нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна.                                                                                                                                                                                                       | 19 |
| БҮЛЭГ 3.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | 22 |
| 3.1. Их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа элэгдлийн фонд, бусад эх үүсвэрийг тооцолгүй төлөвлөсөн байна.                                                                                                                                                                                                                                   | 23 |
| 3.2. Хөрөнгө бэлтгэхдээ аудитад хамрагдсан онуудад ТБОНӨХБАҮХАТХ-ийг баримталж ажиллаагүй бөгөөд 2019 оноос худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна.                                                                                                                                                                                                  | 26 |
| 3.3. Эд хөрөнгө бэлтгэх, данснаас хасахдаа хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлт, орлого зарлагыг бүрэн хийж бүртгэлд тусгаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.                                                                                                                                                                                 | 27 |
| 3.4. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг 2017 оноос байгуулсан хэдий ч зөвлөл нь үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.                                                                                                                                                                                                                                   | 29 |
| БҮЛЭГ 4.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | 30 |
| 4.1.Хөрөнгө оруулалтын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн ч ирээдүйд өгөх эдийн засгийн үр өгөөжийг тооцоолоогүй байна.                                                                                                                                                                                                                                                | 30 |
| 4.2.Төсөл хөтөлбөрийн үр дүнд цэвэр усан хангамжийн үйл ажиллагаа стандартын дагуу хүртээмжтэй хэвийн явагдах нөхцөл бололцоо бүрдсэн байна.                                                                                                                                                                                                                            | 31 |
| 4.3. Компанийн үйлдвэрлэл үйлчилгээний өртгийг хагас бүтэн жилээр алба хэсэг бүрээр тооцож компанийн алдагдалгүй ажиллах арга хэмжээг авч ажилласнаар компанийн алдагдлыг бууруулж ажилласан байна.                                                                                                                                                                     | 33 |
| АУДИТЫН ДҮГНЭЛТ                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 35 |
| АУДИТЫН ЗӨВЛӨМЖ                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 37 |

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол улсын Ерөнхий аудиторын Орлогчийн “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2019 оны А/103 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### Аудитын зорилт, хамарсан хүрээ

“Чандмань-Баянхонгор” ХК-ийн үйл ажиллагааны үр дүнг шалгаж, аудитын дүн, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Үүнд :

1. Орлого, зардлын төлөвлөлт, гүйцэтгэл оновчтой, үр дүнтэй эсэх?
2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, түүнд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?
3. Тайлант онуудын Их засвар техник зохион байгуулалтын арга хэмжээг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Аудитыг “Чандмань-Баянхонгор” ХК-ийн дүрэм, ТУЗ-ийн тогтоол, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, 2015-2017 оны санхүүгийн тайлан, мэдээ, хэрэглэгчидтэй байгуулсан гэрээ, тоолууртай хэрэглэгчийн бүртгэл, холбогдох бусад материалд тулгуурлан гүйцэтгэв.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Компанийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж

- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдан, аудитын менежер Д.Цэцэгмаа аудитын үе шат бүрд хяналт тавьж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Н.Бүнчинсүрэн нар 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж, аймгийн ИТХ, Засаг дарга болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

#### Үндсэн мэдээлэл

“Чандмань-Баянхонгор” ХК нь Баянхонгор аймгийн ИТХ-ын ээлжит бус XVIII хуралдаанаар хувьцаат компани болон зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж иржээ.

Дүрэмд “нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3922938 ширхэг энгийн хувьцаатай байна. Хувьцааны 51 хувь буюу 2000698 ширхэг хувьцаа нь аймгийн ИТХ, 20 хувь буюу 784588 ширхэг хувьцааг ажилчдад эзэмшүүлж, 29 хувь буюу 1137652 ширхэг хувьцааг нээлттэй арилжина” гэж заасан байна.

Тус компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг хүснэгтээр авч үзвэл:

| Үзүүлэлт                              | 2015 он        | 2016 он      | 2017 он        |
|---------------------------------------|----------------|--------------|----------------|
| Мөнгөн хөрөнгө                        | 65.6           | 18.5         | 17.2           |
| Авлага                                | 143.0          | 84.3         | 55.7           |
| Бараа материал                        | 118.5          | 92.4         | 90.8           |
| Урьдчилж төлсөн зардал                | 1.5            | 0.5          | 0.7            |
| Бусад эргэлтийн хөрөнгө               | 2.9            |              |                |
| Үндсэн хөрөнгө                        | 695.8          | 788.9        | 1,186.0        |
| Биет бус хөрөнгө                      | 154.8          |              |                |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>             | <b>1,182.1</b> | <b>984.6</b> | <b>1,350.4</b> |
| Өр төлбөр                             | 367.7          | 145.7        | 325.6          |
| Богино хугацаат өр төлбөр             | 47.3           | 46.3         | 89.9           |
| Урт хугацаат өр төлбөр                | 320.4          | 99.4         | 235.7          |
| Эздийн өмч                            | 814.4          | 838.9        | 1,024.8        |
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b> | <b>1,182.1</b> | <b>984.6</b> | <b>1,350.4</b> |

Тус компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөөг жил бүр ТУЗ-өөр батлуулж ирсэн бөгөөд үр дүнг хүснэгтээр харуулбал:

| Үзүүлэлт                | 2015 он    |           | 2016 он    |           | 2017 он    |           |
|-------------------------|------------|-----------|------------|-----------|------------|-----------|
|                         | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| Борлуулалтын орлого     | 1,403.4    | 1,107.2   | 918.6      | 933.4     | 1,091.1    | 1,120.2   |
| нийт зардал             | 1,398.5    | 1,214.8   | 894.2      | 972.1     | 1,079.1    | 1,003.5   |
| татварын өмнөх ашиг     | 4.9        | (107.6)   | 24.4       | (38.7)    | 12.0       | 116.7     |
| Орлогын татварын зардал | 0.5        | -         | 2.4        | -         | 1.2        | 11.7      |
| Цэвэр ашиг              | 4.4        | (107.6)   | 22.0       | (38.7)    | 10.8       | 105.0     |

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

### БҮЛЭГ 1.

Цэвэр усан хангамж ариутгах татуургын талаар орон нутгаас хэрэгжүүлэх бодлогыг Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж хэрэгжилтийг тухай бүрт нь тооцож ажилласан байна.

#### 1.1.Цэвэр усан хангамж, ариутгах татуургыг хөгжүүлэх бодлогыг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгаж хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Ус хангамж, ариутгах татуургын талаар баримтлах бодлого, чиглэлийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан байна.

“Баянхонгор аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 1-р бүлгийн 1.4-т Эдийн засгийн хөгжлийг дэмжих, тогтвортой өсөлтийг хангах дэд бүтцийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлсон байна. Тухайлбал:

/Хүснэгт №1/

| Тусгасан арга хэмжээ                                                                                              | Хэрэгжилт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | ИТХ-ын дүгнэсэн байдал |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|
| 1.4.8-д Баянхонгор сумын гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийн хэрэгжүүлж, инженерийн шугам сүлжээ байгуулна. | <p><b>1. Аймгийн төвийн гэр хорооллын инженерийн байгууламж, шугам сүлжээ, зураг төсөв ТЭЗҮ боловсруулах. Үүнд:</b><br/>Аймгийн төвийн 3, 6, 9 дүгээр багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний зураг төсөв, ТЭЗҮ-ийг “ОСИБ”- 3Т ХХК 2,4,5,7 дугаар багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний зураг төсөв, ТЭЗҮ-5 ийг “ДНТ” ХХК тус тус гүйцэтгэж Барилга хөгжлийн төвөөр хянуулан хүлээн авсан.</p> <p><b>2. Аймгийн төвийн гэр хорооллын инженерийн байгууламж, шугам сүлжээг барьж эхлэх. Үүнд:</b><br/>Аймгийн төвийн 3 дугаар багт 1510 м бохир, 865 м дулааны хос, цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилгын ажлыг Хот байгуулалтын МОН-2301 төслийн 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Сан констракшн” ХХК, Туслан гүйцэтгэгчээр “Чандмань-Баянхонгор” ХК шалгарч шугам сүлжээний угсралтын ажлыг бүрэн дуусгасан. 9 дүгээр багт бохир усны 1300 м шугамын ажлыг Хот байгуулалтын МОН-2301 төслийн 1,2 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хөх бүрдний эх” ХХК шалгарч шугам сүлжээний угсралтын ажлыг хийж дуусгасан. 9-р багийн инженерийн шугам сүлжээ барих ажлыг Альфа асфальт ХХК гүйцэтгэж, ажил хийгдэж дууссан.</p> | Хэрэгжилт<br>100 %     |
| 1.4.15-д “Орон сууцны 12,13,14,17,18 дугаар байрны гадна ариутгах татуургын шугамын шинэчлэл”                     | Орон сууцны 17, 18, 13, 14, 12 дугаар байрны гадна ариутгах татуургын шугамын шинэчлэлийн ажлыг “Хөх бүрдний эх” ХХК хийхээр 2012.11.07 ны өдөр 259.8 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж 2013-06-20-ний өдөр ашиглалтад оруулсан. Нийт 1300 м төв магистрал шугам бохирын худаг зэргийг шинэчилсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Хэрэгжилт<br>100 %     |

“Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 4 дүгээр бүлэгт тусгасан Дэд бүтцийн хөгжлийн бодлого, түүний хэрэгжилтийг судалж үзэхэд дараах байдалтай байна.Үүнд:

/Хүснэгт № 4/

| Тусгасан арга хэмжээ                                                                                                                                                                                                                                                                    | Хэрэгжилт                                                                                                                                                                                                                                            | ИТХ-ын дүгнэсэн байдал |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|
| 120-д “Баянхонгор сумын цэвэрлэх байгууламжид хэт ягаан туяаны цэвэршүүлэгч суурилуулна”                                                                                                                                                                                                | 2019 оны 06-р сарын 26-ны байдлаар хэрэгжээгүй байна                                                                                                                                                                                                 | Хэрэгжилт<br>0 %       |
| 121-д “Баянхонгор сумын орон сууцны хуучин барилгуудыг буулгаж шинээр барих, өнгө үзэмжийг сайжруулах, гадна орчны тохижилт хийх, инженерийн шугамыг шинэчлэх төсөл хэрэгжүүлэн оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, үйлчилгээг СӨХ-д шилжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2017 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 12, 13, 14, 17 байрнуудад засвар хийхдээ зоорын давхрын бохир усны шугамыг бүрэн шинэчилсэн.                                                                                                                     | Хэрэгжилт<br>100 %     |
| 123-д Стандартын шаардлага хангасан байнгын ашиглалттай усан сангуудыг төвлөрсөн шугамд холбож холбогдох мэргэжлийн байгууллагад нь харьяалуулна.                                                                                                                                       | 2018 оны хөрөнгө оруулалтаар хувийн усан сангуудыг “Чандмань-Баянхонгор” ХК –д шилжүүлэн авсан бөгөөд нийт 12 усан санг орчин үеийн смарт карт ашиглан ухаалаг усан сан бий болгосноор ундны усны эрүүл ахуй, үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан. | Хэрэгжилт<br>100 %     |

Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 121-д “Оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, үйлчилгээг СӨХ-д шилжүүлэх ажлыг зохион байгуулна” гэсэн заалтыг аймгийн ИТХ-аар 100 хувь хэрэгжилттэй гэж дүгнэсэн боловч СӨХ байгуулагдаагүй байна

Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс жил бүр эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл баталж, хэрэгжилтийг ИТХ-аар дүгнэж ажилласан байна. /Хэрэгжилт дүгнэсэн байдлыг хүснэгт №1, 2-т харуулав/

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг аймгийн ИТХ-аар тогтоохоор заажээ.

### Аудитын илрүүлэлт

“Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс”-ийг 2011.03.16-ний өдөр аймгийн Засаг даргын №109 тоот захирамжаар, 2017.10.03-ний өдөр Баянхонгор сумын Засаг даргын № 242 тоот захирамжаар тус тус тогтоосон байгаа нь дээрх хуулийн заалтад нийцэхгүй байна.

Иймд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-д “нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ундны усны эх үүсвэр, шугам

сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлэв.

Усны эх үүсвэр, дахин дамжуулах төвийн хамгаалалтыг “Даяар трейд”ХХК-ний дохиолол хамгаалалтаар хамгаалуулж байгаа нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Улсын онц чухал объектод хамаарах ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг дотоодын цэрэг гүйцэтгэж, бусад ус хангамжийн эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байна” гэсэн заалтыг хангахгүй байна.

Иймд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д гэсэн заалтыг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог судалж, усны аюулгүй байдлыг хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв

**1.2. “Чандмань-Баянхонгор” ХК нь хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэр гарч, дүрмийг өөрчлөн улсын бүртгэлд бүртгүүлсэн хэдий ч хуульд заасан шаардлагын дагуу үнэт цаасаа бүртгүүлээгүй, компанийн дүрмийг баримталж ажиллаагүй байна.**

Аймгийн ИТХ-ын 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит бус XVIII хуралдаанаар “Чандмань-Баянхонгор” ХХК-ийг хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэж, хувьцааны 51 хувийг орон нутгийн өмчид, 20 хувийг ажилчдад эзэмшүүлж, 29 хувийг орон нутгийн иргэдэд арилжих шийдвэр гарч хувьцаат компанийн дүрмийг шинэчлэн баталж, 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос аймгийн санхүүгийн зохицуулах хорооны орон нутаг дахь төлөөлөгчид 2018 оны 02 дугаар сарын 01 –нд ирүүлсэн 9/304 тоот албан бичигт:

“Компанийн тухай хуулийн 3.8-д “Хаалттай хувьцаат компани” гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг хэлнэ”, Хорооны 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 160 дугаар тогтоолоор баталсан “Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 4.2-т “Хадгалагч нь хадгалуулагчтай хувьцааны хадгаламжийн болон түүнтэй холбоотой төлбөр гүйцэтгэх гэрээ байгуулна” гэж заасны дагуу “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д үнэт цаасаа

бүртгүүлээгүй, гэрээ байгуулаагүй тул “Чандмань-Баянхонгор”ХХК-ийг хаалттай хувьцаат компани гэж үзэх үндэслэлгүй байна. Иймд “Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 3.1-т заасан холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, компанийн тухай хуулийн 3.8-д заасны дагуу “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д үнэт цаасаа бүртгүүлснээр “Чандмань-Баянхонгор” ХХК-ийг хувьцаат компанийн хэлбэр, хаалттай хувьцаат компанийн төрөлд хамаарагдахаар байна” гэжээ.

Хаалттай хувьцаат компанийг хуулийн дагуу зохион байгуулаагүйгээс тус компанийн үйл ажиллагаа нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн зарчмаар ажиллаж ирсэн байна. Иймд компанийн үйл ажиллагааг компанийн батлагдсан дүрмийн дагуу явуулж, хуулийн зөрчлийг арилгах зөвлөмжийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, болон компанийн гүйцэтгэх удирдлагад зөвлөв.

Компанийн тухай хуулийн 75.4-д “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасан байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2012 оны 10 дугаар тогтоолоор төлөөлөн удирдах зөвлөлийг 7 гишүүнтэй томилохдоо хараат бус гишүүний шалгуурыг хангасан 1 гишүүн томилсон.

2013 оны хувьцаа эзэмшигчийн хуралдааны 1 дүгээр тогтоолоор ТУЗ-ийг 9 гишүүнтэй томилохдоо хараат бус гишүүний шалгуур хангасан 3 гишүүн томилжээ.

#### **Аудитын илрүүлэлт:**

2016 онд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 61 дүгээр тогтоолоор төлөөлөн удирдах зөвлөлийг 7 гишүүтэй томилохдоо хараат бус гишүүний шалгуурыг хангасан 2 гишүүн томилж, ИТХ-ын тэргүүлэгчдийн 103 тоот тогтоолоор 2 гишүүн нэмэхдээ ИТХ-ын төлөөлөгчид нэмсэн, ИТХ-ын тэргүүлэгчдийн 28 дугаар тогтоолоор Хараат бус 1 гишүүн төрийн албанд томилогдсон учир чөлөөлж, дараагийн гишүүнийг томилохдоо төрийн үйлчилгээнийхээс бусад албан хаагч томилсон, ИТХ-ын тэргүүлэгчдийн 72 дугаар тогтоолоор өөрчилсөн гишүүн нь хараат бус гишүүний шаардлага хангаагүй байна. Одоогийн ажиллаж буй 9 гишүүний 1 гишүүн нь хараат бус гишүүний шаардлага хангасан байна.

Иймд Компанийн тухай хуулийн 75.4 дэх заалтыг хангасан ТУЗ-ийг шинэчлэн байгуулах зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлэв.

“Чандмань-Баянхонгор ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 07-р сарын 25-ний өдрийн №01 тоот тогтоолоор компанийн гүйцэтгэх захирлаар Эрдэнээ овогтой Энхбатыг томилж 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31 хүртэл гэрээ байгуулж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр гэрээг үргэлжлүүлэн байгуулж 2020 оны 12 дугаар сарын 31-нд хугацаа дуусахаар байгуулсан нь Компанийн тухай хуулийн 83.6-д заасан “Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна” гэсэн заалтыг хангаж байна.

### Компанийн үнэ тарифтай холбоотой эрх зүйн орчин:

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9.1-д “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл /цаашид “Зохицуулах зөвлөл” гэх/ нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй байна” гэж заасны дагуу Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс “Чандмань-Баянхонгор” ХК-ийн аргачлалын дагуу тооцож гаргасан тооцоонд тулгуурлан **2015 оны 01 дүгээр сарын 13-ний өдөр** усны үнийг тогтоосон байна.

### Цэвэр ус

/ төгрөгөөр/

| Орлогын төвүүд |                                   |            | хэмжих нэгж | 2009 оноо мөрдөгдсөн үнэ | Тооцсон өөрийн өртөг | Компаниас Санал болгосон тариф | Баталсан үнийн тариф |
|----------------|-----------------------------------|------------|-------------|--------------------------|----------------------|--------------------------------|----------------------|
| Төвлөрсөн      | айл                               | тоолууртай | м3          | 600                      | 649                  | 1300                           | <b>700</b>           |
|                | өрх                               | тоолуургүй | м3          | 1200                     | 870                  | 2600                           | <b>1600</b>          |
|                | ААНБ                              | тоолууртай | м3          | 1300                     | 1404                 | 2974                           | <b>1600</b>          |
|                |                                   | тоолуургүй | м3          | 1300                     | 1404                 | 2974                           | <b>1600</b>          |
|                | УТБ төвлөрсөн                     |            | м3          | 3000                     | 2170                 | 3000                           |                      |
| Зөөвөр         | Хүн ам /зөөврөөр                  |            | м3          | 1200                     | 870                  | 2600                           | -                    |
|                | Ус түгээх байранд /зөөврөөр/      |            | м3          | 3000                     | 2170                 | 3000                           | -                    |
|                | Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага |            | м3          | 1300                     | 1404                 | 2974                           | -                    |

### Ариутгах татуурга

/ төгрөгөөр/

| Орлогын төвүүд |      |            | хэмжих нэгж | 2009 оноос мөрдөгдсөн үнэ | Тооцсон өөрийн өртөг | Компаниас Санал болгосон тариф | Баталсан үнийн тариф |
|----------------|------|------------|-------------|---------------------------|----------------------|--------------------------------|----------------------|
| Төвлөрсөн      | айл  | тоолууртай | м3          | 230                       | 309                  | 700                            | <b>320</b>           |
|                | өрх  | тоолуургүй | м3          | 600                       | 687                  | 1300                           | <b>1000</b>          |
|                | ААНБ | тоолууртай | м3          | 1000                      | 1111                 | 2100                           | <b>1300</b>          |
|                |      | тоолуургүй | м3          | 1000                      | 1111                 | 2100                           | <b>1300</b>          |

|                                      |           |       |       |              |
|--------------------------------------|-----------|-------|-------|--------------|
| Зөөврөөр бохир ус татан<br>зайлуулах | Төг/машин | 25600 | 26500 | <b>26500</b> |
|--------------------------------------|-----------|-------|-------|--------------|

Мөн тус тогтоолын 2 дугаар хавсралтаар усны үйлчилгээний суурь хураамжийг баталсан байна. Суурь хураамжийг айл өрх сард 1800 төгрөг, албан байгууллага оролтын шугамын голчоос хамаарч ф15-ф150-ийн голчтой бол 3600-104800, 400-аас дээш голчтой бол 384000 төгрөг байхаар тогтоосон байна.

**2017 оны 05 дугаар сарын 19-нд** Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс “Чандмань-Баянхонгор” ХК-ийн үйлчилгээний төлбөрийг тарифыг шинэчлэн тогтоосон байна.

**Цэвэр ус**

/төгрөгөөр/

| Орлогын төвүүд |                                      |              | хэмжих<br>нэгж | 2015 оноо<br>мөрдөгд-<br>сөн үнэ | Компаниас<br>Санал<br>болгосон<br>тариф | Баталсан<br>үнийн<br>тариф | Үнийн<br>өөрчлөлт<br>/2015<br>оноос/ |
|----------------|--------------------------------------|--------------|----------------|----------------------------------|-----------------------------------------|----------------------------|--------------------------------------|
| Цэвэр ус       | айл<br>өрх                           | тоолууртай   | м3             | <b>700</b>                       | 700                                     | <b>700</b>                 | <b>0</b>                             |
|                |                                      | тоолуургүй   | м3             | <b>1600</b>                      | 3150                                    | <b>1000</b>                | <b>-600</b>                          |
|                | ААНБ                                 | тоолууртай   | м3             | <b>1600</b>                      | 1600                                    | <b>1600</b>                | <b>0</b>                             |
|                |                                      | Төсөвт газар |                | <b>1600</b>                      | 5000                                    | <b>4000</b>                | <b>2400</b>                          |
|                |                                      | тоолуургүй   | м3             | <b>1600</b>                      | 0                                       | -                          | -                                    |
|                | УТБ төвлөрсөн                        |              | м3             |                                  | 1000                                    | <b>910</b>                 | -                                    |
| Зөөвөр         | Хүн ам /зөөврөөр                     |              | м3             |                                  | -                                       | <b>910</b>                 | -                                    |
|                | Ус түгээх байранд<br>/зөөврөөр/      |              | м3             |                                  | 1000                                    | <b>1000</b>                | -                                    |
|                | Үйлдвэр аж ахуйн нэгж<br>байгууллага |              | м3             |                                  | 1000                                    | <b>1000</b>                | -                                    |

**Ариутгах татуурга**

/ төгрөгөөр/

| Орлогын төвүүд                       |            |              | хэмжих<br>нэгж | 2015 оноос<br>мөрдөгд-<br>сөн үнэ | Компаниас<br>Санал<br>болгосон<br>тариф | Баталсан<br>үнийн<br>тариф | Үнийн<br>өөрчлөлт<br>/2015<br>оноос/ |
|--------------------------------------|------------|--------------|----------------|-----------------------------------|-----------------------------------------|----------------------------|--------------------------------------|
| Төвлөрсөн                            | айл<br>өрх | тоолууртай   | м3             | 320                               | 320                                     | 320                        | 0                                    |
|                                      |            | тоолуургүй   | м3             | 1000                              | 1440                                    | 700                        | -300                                 |
|                                      | ААНБ       | тоолууртай   | м3             | 1300                              | 1300                                    | 1300                       | 0                                    |
|                                      |            | Төсөвт газар |                | 1300                              | 3500                                    | 2800                       | 1500                                 |
|                                      |            | тоолуургүй   | м3             | 1300                              | 1300                                    | -                          | -                                    |
| Зөөврөөр бохир ус татан<br>зайлуулах |            |              | Төг/маши<br>н  | 26500                             | 20000                                   | 20000                      | -6500                                |

2017 онд цэвэр бохир усны тоолуургүй хэрэглэгчийн үнийг хүн сараар тооцдог байсныг м3-ээр 1 хүнд хоногт 200 литр усны норматив тогтоож өгсөн байна. Харин төсөвт газрын усны үнийг цэвэр усанд метр куб тутамд 2400 төгрөгөөр, бохир усанд метр куб тутамд 1500 төгрөг болж өөрчлөгдсөн байна.

**БҮЛЭГ 2.**

Төлөвлөлтийг үндэслэл муутай хийснээс орлогын төлөвлөгөө тасрах, батлагдаагүй зардал гарах, зарим төрлийн зардлыг хэтрүүлэх зөрчлүүд гарах шалтгаан болсон байна.

**2.1. Компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа үндэслэл муутай төлөвлөснөөс орлогын төлөвлөгөө тасрах, батлагдаагүй зардал гаргасан нь алдагдалтай ажиллах шалтгаан болсон байна.**

Аж ахуйн нэгж байгууллагатай 2015 онд цэвэр, бохир усны 238, дулаанаар хангах 111 гэрээ байгуулж ажиллахаас бүрэн байгуулж ажилласан байна. Харин тухайн жилийн борлуулалтын бичилтээс харахад 2226 айл өрхтэй гэрээ байгуулж ажиллахаар байхад гэрээ байгуулсан эсэх нь тодорхойгүй, гэрээ байгуулсан бүртгэл байхгүй байна. Энэ талаар борлуулалтын нягтлан бодогчоос тодруулахад “2014 онд шинэ дэвтэр олгосон, тухайн дэвтрийн хавтсанд гэрээг тусгасан байгаа бидэнд бол авч үлдсэн гэрээний хувь байхгүй” гэсэн тайлбар өгөв.

2016 онд цэвэр бохир усны гэрээг 243 аж ахуйн нэгжтэй байгуулахаас 225, дулаанаар хангах 129 байгууллагын гэрээг бүрэн байгуулж ажилласан байна. Цэвэр бохир усаар хангах гэрээг 18 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулаагүй байна. Энэ талаар борлуулалтын нягтлан бодогчоос тодруулахад “Тухайн онд шинээр холболт хийгдсэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулалгүй тоолуураар авч тооцож авдаг бөгөөд эхний 2,3 сардаа хэрэглээг нь хянаж үзэж байж гэрээ байгуулдаг” гэсэн тайлбар өглөө.

Тухайн онд айл өрхтэй байгуулах гэрээний маягт, бичилт хийх дэвтрийг шинээр 2600 ширхгийг хэвлүүлсэн бөгөөд тухайн жилийн борлуулалтын бичилтээс харахад 2385 айл өрхтэй гэрээ байгуулж ажиллахаар байхад 1809 айл өрхөд 1000 төгрөгийн үнэ бүхий дэвтэр борлуулснаас харахад дээрх хэмжээний айл өрхтэй гэрээ хийсэн гэж үзэхээр байна.

2017 онд аж ахуйн нэгж байгууллагын цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах гэрээг 2016 онд байгуулсан гэрээний 9-р бүлгийн 7-р зүйлд “аль нэг тал гэрээнд өөрчлөлт оруулах санал гаргаагүй бол гэрээг 2 жилээр сунгагдсанд тооцож төлбөр тооцно” гэж заасны дагуу гэрээ сунгагдсан байна.

Харин айл өрхтэй 2016 онд байгуулсан гэрээний хавсралтад гэрээний сунгалтыг заасан боловч сунгалт хийсэн бүртгэлийг баримтжуулаагүй бичилт хийсэн нь тодорхойгүй байна.

### **Аудитын илрүүлэлт:**

Дээрх нөхцөл байдлаас харахад хэрэглэгчидтэй гэрээ хийж байгаа боловч гэрээний бүртгэлийг хөтөлдөггүй, гэрээ бүрэн байгуулсан эсэх нь тодорхойгүй байгаа нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13.2-т заасан “Хангагч нь Зохицуулах зөвлөлийн баталсан аж ахуйн харилцааны дүрмийн дагуу хэрэглэгчтэй гэрээ байгуулна” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд цаашид гэрээ байгуулж ажиллах хэрэглэгчийн тоог үнэн зөв гаргаж, гэрээг бүрэн байгуулж, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллахыг компанийн гүйцэтгэх захиралд зөвлөв.

| д/д | Он   | Ус ашиглалтын тайлан /Цэвэр ус м3/ | Борлуулалтын тайлан /Цэвэр ус м3/ | Зөрүү /м3/ |
|-----|------|------------------------------------|-----------------------------------|------------|
| 1   | 2015 | 200546                             | 177623,58                         | 22922,42   |
| 2   | 2016 | 168295                             | 148238                            | 20057      |
| 3   | 2017 | 151533                             | 133691,9                          | 17841,1    |
|     | Дүн  | 520374                             | 459553,48                         | 60820,52   |

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд жил бүр ус ашиглалтын тайланг харилцагч бүрээр гаргаж хүргүүлж

байгаа бөгөөд аудитаар дээрх тайланг борлуулалтын журналтай тулгав.

Хүснэгтээс харахад ус ашиглалтын тайлан нь борлуулалтын тайлантай тохирохгүй байна.

Үүнийг ерөнхий инженерээс тодруулахад “ус алдагдлыг бага харагдуулах зорилгоор задгайгаар бичдэг төсөвт АА-н нэгжүүдийг зуны сард нь хэрэглээг адилхан тавьсан, мөн компанийн өөрийн дотоод хэрэглээг нэмсэн, зэрэг шалтгаануудаас зөрж байгаа” гэсэн тайлбар өгөв.

### **Аудитын илрүүлэлт:**

Дээрх байдлаас харахад борлуулалтын албанаас борлуулсан усны хэмжээг бодитоор авдаггүйгээс ус ашиглалтын тайланг үнэн зөв гаргахгүй байна.

Иймд цаашид усны тайланг гаргахдаа борлуулалтын албатай бодит тоог уялдуулан үнэн зөв гаргаж байх зөвлөмжийг компанийн гүйцэтгэх удирдлагад хүргүүлэв.

**Аудитын илрүүлэлт:**

Тоолуурын бичилтийн журналыг борлуулалтын тайлантай тулган үзэхэд төсөвт албан газруудын борлуулалтын бичилт нь тоолуурын бичилтээс өндөр байв. Үүнийг хүснэгтээр харуулбал:

| д/д             | Байгууллагын нэр      | Тоолуур | Бор-ын Журнал | Зөрүү м3 | Цэвэр ус /мян. төг/ | Бохир ус /м3/ | Бохир ус /мян. Төг/ | Дүн     |
|-----------------|-----------------------|---------|---------------|----------|---------------------|---------------|---------------------|---------|
| <b>2015 онд</b> |                       |         |               |          |                     |               |                     |         |
| 1               | Номгон ахлах сургууль | 9069.4  | 10023.6       | 954.2    | 1679.4              | 925.5         | 1323.5              | 3002.9  |
| 2               | 12-р цэцэрлэг         | 1307.0  | 1643.5        | 336.5    | 592.2               | 269.2         | 385.0               | 977.2   |
| 3               | Хүүхдийн төлөө төв    | 126.0   | 304.6         | 178.6    | 314.3               | 126.0         | 180.2               | 494.5   |
| 4               | Сумын ЗДТГазар        | 503.0   | 644.8         | 141.8    | 249.6               | 99.3          | 141.9               | 391.5   |
| 5               | Эрдэм                 | 2408.0  | 2479.0        | 71.0     | 125.0               | 71.0          | 101.5               | 226.5   |
| 6               | 3-р цэцэрлэг          | 2715.0  | 2826.0        | 111.0    | 195.4               | 111.0         | 158.7               | 354.1   |
|                 | Дүн                   | 16128.4 | 17921.5       | 1793.1   | 3155.9              | 1602.0        | 2290.8              | 5446.7  |
| <b>2016 онд</b> |                       |         |               |          |                     |               |                     |         |
| 1               | Эрдэм ахлах сургууль  | 2291.0  | 2870.2        | 579.2    | 1019.4              | 544.4         | 778.5               | 1797.9  |
| 2               | 5-р цэцэрлэг          | 418.0   | 783.5         | 365.5    | 643.2               | 276.6         | 395.5               | 1038.7  |
| 3               | 10-р цэцэрлэг         | 375.0   | 1190.0        | 815.0    | 1434.4              | 749.8         | 1072.2              | 2506.6  |
| 4               | Номгон                | 4348.1  | 5936.1        | 1588.0   | 2794.9              | 1588.0        | 2270.8              | 5065.7  |
| 5               | 3-р цэцэрлэг          | 1634.0  | 1744.0        | 110.0    | 193.6               | 96.1          | 137.4               | 331.0   |
| 6               | 12-р цэцэрлэг         | 643.0   | 792.3         | 149.3    | 262.8               | 89.6          | 128.1               | 390.9   |
| 7               | Эрдэнэмандал          | 10374.0 | 15492.6       | 5118.6   | 9008.7              | 3583.0        | 5123.7              | 14132.4 |
| 8               | Цагдаагийн хэлтэс     | 1102.0  | 1645.5        | 543.5    | 956.6               | 380.4         | 544.0               | 1500.5  |
|                 | Дүн                   | 21185.1 | 30454.1       | 9269.1   | 16313.5             | 7307.9        | 10450.3             | 26763.8 |
|                 | Нийт дүн              | 37313.5 | 48375.6       | 11062.2  | 19469.4             | 8909.9        | 12741.1             | 32210.5 |

Дээрх хүснэгтээс харахад орлогын бодит хэмжээнээс 32,2 сая төгрөгийг илүү авсан байна. Харин 2017 оноос төсөвт байгууллагуудын төсөвт тааруулан тоолуур хэрэглэхгүй задгайгаар тооцдог болсон тул дээрх зөрүү гараагүй.

**Аудитын илрүүлэлт:**

Төслийн хөрөнгө оруулалтаар хэрэглэгчдийг тоолууржуулж, шоо метр тутамд авах үнийг ялгаатай тогтоосоор байтал төсөвт байгууллагын хэрэглэгчдээс задгайгаар хэрэглээг тооцож байгаа нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20.1-д заасан “Хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээг энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу байгуулсан гэрээ, эрх бүхий байгууллагаар баталгаажсан усны тоолуурын заалтыг үндэслэн тооцно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд цаашид бодит хэрэглээг тоолуураар тооцож, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж компанийн гүйцэтгэх удирдлагад хүргүүлэв.

Аудитаар “Чандмань-Баянхонгор” ХК-ийн 2015-2017 оны ТУЗ-өөр батлагдсан бизнес төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийв.

Санхүүгийн төлөвлөгөө:

/сая.төг/

| № | Үзүүлэлт                | 2015   | 2016  | 2017   |
|---|-------------------------|--------|-------|--------|
| 1 | Борлуулалтын орлого     | 1403.4 | 918,6 | 1091,1 |
| 2 | Нийт зардал             | 1398.4 | 894.2 | 1079,1 |
| 3 | Татварын өмнөх ашиг     | 4.9    | 24.4  | 12,0   |
| 4 | Орлогын татварын зардал | 0.5    | 2.4   | 1,2    |
| 5 | Цэвэр ашиг              | 4.4    | 22.0  | 10,8   |

ТУЗ-аар батлуулсан орлогын төлөвлөгөө айл өрх, АА-н нэгж байгууллагаар тооцсон дүнтэй тулган үзэхэд дараах байдалтай байна.

| Орлогын төвүүд |                              |         | 2015 он               |                     | 2016 он               |                     | 2017 он               |                     |
|----------------|------------------------------|---------|-----------------------|---------------------|-----------------------|---------------------|-----------------------|---------------------|
|                |                              |         | ТУЗ-өөр<br>батлуулсан | Орлогын<br>задаргаа | ТУЗ-өөр<br>батлуулсан | Орлогын<br>задаргаа | ТУЗ-өөр<br>батлуулсан | Орлогын<br>задаргаа |
| Цэвэр ус       | айл өрх                      |         | 63,4                  | 49,5                | 75,4                  | 75,4                | 109,3                 | 109,3               |
|                | ААНБ                         |         | 385,1                 | 187,2               | 305,0                 | 305,0               | 244,3                 | 244,3               |
|                | УТБ зөөвөр                   |         | 7,5                   |                     | 22,1                  | 22,1                | 23,7                  | 23,7                |
|                | Зөөвөр ААНБ                  |         | 8,1                   |                     | 0,2                   | 0,2                 |                       |                     |
| Бохир ус       | айл өрх                      |         | 36,2                  | 46,2                | 39,5                  | 39,5                | 67,3                  | 51,9                |
|                | ААНБ                         |         | 303,4                 | 113,5               | 182,3                 | 182,3               | 166,7                 | 166,7               |
| Суурь хураамж  | айл өрх                      |         | 47,8                  | 47,8                | 49,7                  | 49,7                | 48,8                  | 48,8                |
|                | ААНБ                         |         | 21,2                  | 21,2                | 21,2                  | 21,2                | 20,1                  | 20,1                |
| Дулаан         | төв зуух                     | айл өрх | 53,2                  | 53,2                |                       |                     |                       |                     |
|                |                              | ААНБ    | 280,4                 | 280,4               |                       |                     |                       |                     |
|                | захын зуух                   | айл өрх | 0,8                   | 0,8                 | 0,8                   | 0,8                 |                       |                     |
|                |                              | ААНБ    | 176,3                 | 168,2               | 222,5                 | 222,5               | 241,8                 | 241,8               |
|                | Цэцэрлэгүүд, Багийн төвүүд   |         |                       |                     |                       |                     | 165,0                 | 165,0               |
| буса д         | Бусад үйл ажиллагааны орлого |         | 20,0                  |                     |                       |                     | 4,1                   | 4,1                 |
| Нийт орлого    |                              |         | 1403,4                | 968,0               | 918,7                 | 918,7               | 1091,1                | 1075,7              |

2015 оны борлуулалтын орлогын нэр төрлийн төлөвлөгөөний задаргаа нь ТУЗ-аар батлуулсан орлогын төлөвлөгөөнөөс 415,4 сая төгрөгөөр зөрж байна. Энэ талаар тодруулга авах гэсэн боловч эдийн засагч өвчтэй байсан учраас тодруулга авч чадаагүй болно. Иймд шалтгааныг тайлан ИТХ-аар хэлэлцэгдэх үед тайлбар өгөхийг гүйцэтгэх удирдлагад хариуцуулав.

2016 онд орлогын задаргаа нь ТУЗ-аар батлуулсан орлогын төлөвлөгөөтэй уялдаж байна.

2017 онд 15.4 сая төгрөгөөр айл өрхөөс авах бохир усны төлбөрийн зөрүүлж төлөвлөснөөс харахад орлогыг төлөвлөхдөө бодит хэмжээг тооцолгүй батлуулж байна.

ТУЗ-аар 2015 онд 1398,5 сая, 2016 онд 894,2 сая, 2017 онд 1079,1 сая төгрөгийн зардал батлуулан үйл ажиллагаа явуулсан байна.

Аудитаар төлөвлөсөн зардлыг тооцсон задаргаагаар нь тулгаж үзэв. Зардлыг төлөвлөхдөө тооцсон тооцоотой уялдуулахгүйгээр зардлын нэгтгэлд өөр дүнгээр тусгаж төлөвлөгөөгөө батлуулж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

| Санхүүгийн<br>үзүүлэлтүүд                 | 2015 он         |                     |             | 2016 он         |                     |             | 2017 он         |                     |             |
|-------------------------------------------|-----------------|---------------------|-------------|-----------------|---------------------|-------------|-----------------|---------------------|-------------|
|                                           | ТУЗ<br>баталсан | Зардлын<br>Задаргаа | Зөрүү       | ТУЗ<br>баталсан | Зардлын<br>Задаргаа | Зөрүү       | ТУЗ<br>баталсан | Зардлын<br>Задаргаа | Зөрүү       |
| Цалин хөлс,<br>түүнтэй адилтгах<br>зардал | 629.3           | 629,3               | 0           | 468.7           | 468,7               |             | 599.1           | 599,1               | 0           |
| Шагнал<br>урамшуулал<br>нийгмийн халамж   | 58.8            | 27,0                | 31,8        | 8.9             | 6,3                 | 2,6         | 6.3             | 11,7                | -5,4        |
| Ашиглалтын<br>зардал                      | 526.8           | 534,0               | -7,2        | 284.5           | 240,2               | 44,3        | 348.2           | 256,8               | 91,4        |
| Бараа<br>материалын<br>зардал             | 65.2            | 63,0                | 2,2         | 30.0            | 22,7                | 7,3         | 25.6            | 20,6                | 5           |
| Засварын зардал                           | 43.6            | 31,0                | 12,6        | 36.0            | 36,0                | 0           | 18.1            | 18,1                | 0           |
| Бусад татвар,<br>төлбөр<br>хураамж        | 74.8            | 67,0                | 7,8         | 66.1            | 59,8                | 6,3         | 81.7            | 85,6                | -3,9        |
| <b>Зардлын дүн</b>                        | <b>1,398.5</b>  | <b>1352,3</b>       | <b>46,5</b> | <b>894.2</b>    | <b>833,7</b>        | <b>60,5</b> | <b>1079.1</b>   | <b>991,9</b>        | <b>87,1</b> |

Дээрх байдлаас харахад зардлын төлөвлөлтийг үндэслэл муутай төлөвлөж батлуулж байна.

**2.2. Борлуулалтын орлогыг тайлагнахдаа зарим орлогыг орхигдуулж тайлагнасан байна.**

Төлөвлөгөөний биелэлтийг орлогын төрлөөр харуулбал:

| Орлогын төвүүд               |                            |         | 2015 он    |           | 2016 он    |           | 2017 он    |           |
|------------------------------|----------------------------|---------|------------|-----------|------------|-----------|------------|-----------|
|                              |                            |         | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| Цэвэр ус                     | айл өрх                    |         | 63,4       | 75,0      | 75,4       | 88,1      | 109,3      | 114,5     |
|                              | ААНБ                       |         | 385,1      | 278,4     | 305,0      | 237,2     | 244,3      | 250,8     |
|                              | УТБ зөөвөр/айл өрх/        |         | 7,5        | 21,5      | 22,1       | 22,9      | 23,7       | 24,4      |
|                              | Зөөвөр ААНБ                |         | 8,1        | 0,2       | 0,2        |           |            |           |
| Бохир ус                     | айл өрх                    |         | 36,2       | 36,3      | 39,5       | 35,7      | 67,3       | 53,4      |
|                              | ААНБ                       |         | 303,4      | 170,2     | 182,3      | 154,2     | 166,7      | 188,8     |
| Цэвэр бохир суурь            | айл өрх                    |         | 47,8       | 40,9      | 49,7       | 46,5      | 48,8       | 49,2      |
|                              | ААНБ                       |         | 21,2       | 18,9      | 21,2       | 21,0      | 20,1       | 20,9      |
| Дулаан                       | төв зуух                   | айл өрх | 53,2       | 60,4      |            |           |            |           |
|                              |                            | ААНБ    | 280,4      | 213,7     |            |           |            |           |
|                              | захын зуух                 | айл өрх | 0,8        | 0,5       | 0,8        | 3,0       |            |           |
|                              |                            | ААНБ    | 176,3      | 160,1     | 222,5      | 223,1     | 251,1      |           |
|                              | Цэцэрлэгүүд, багийн төвүүд |         |            |           |            |           | 165,0      | 146,2     |
| бусад                        | Шуурхай засвар үйлчилгээ   |         |            | 7,8       |            | 3,5       | 4,1        | 6,2       |
| Бусад үйл ажиллагааны орлого |                            |         | 20,0       | 23,3      |            | 23.6      |            | 14.6      |
| Нийт орлого                  |                            |         | 1403,4     | 1107,2    | 918,6      | 858.8     | 1091,1     | 1120.1    |

2015 онд орлогын төлөвлөгөө 299,5 сая төгрөгөөр тасарсан нь АА-н нэгж байгууллагын цэвэр усны түгээлтээс орох орлогыг 99,6 сая төгрөгөөр, бохир усны орлогыг 133,2 сая төгрөгөөр бодит байдлаас өндөр төлөвлөсөн, мөн төв зуухыг 2015 оны 11-р сараас хувьчилсантай холбоотой 66,7 сая төгрөгөөр орлого буурсантай холбоотой байна.

2016 онд 33 аж ахуйн нэгж тоолуур нэмж тавьснаар өмнөх оноос усны хэрэглээ 29386м3-ээр буурч 67,8 сая төгрөгөөр борлуулалт буурсан зэрэг шалтгааны улмаас дээрх онуудад орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

Техникийн нөхцөл олгох үнэ тарифыг 2015 оны 06 дугаар сарын 12 –ний өдрийн захирлын тушаалаар цэвэр бохир усны техникийн нөхцөлийг 220.0 мянган төгрөгөөр дулааны техникийн нөхцөлийг 440.0 мянган төгрөгөөр, 2017 оны 06-р сарын 27-ноос Цэвэр бохир усны техникийн нөхцөлийг 500,0 мянга, дулааны техникийн нөхцөлийг 550,0 мянган төгрөгөөр тус тус тогтоосон байна.

| Он   | Техникийн нөхцөл авсан |                    | Тушаасан |         | Зөрүү |         |
|------|------------------------|--------------------|----------|---------|-------|---------|
|      | тоо                    | Авбал зохих орлого | тоо      | орлого  | тоо   | дүн     |
| 2015 | 26                     | 6916,0             | 12       | 2927,9  | 14    | 3988,1  |
| 2016 | 20                     | 6110,0             | 11       | 2899,1  | 9     | 3210,9  |
| 2017 | 25                     | 13662,0            | 11       | 7363,6  | 14    | 6298,3  |
|      | 71                     | 26688,0            | 34       | 13190,6 | 37    | 13497,3 |

Техникийн нөхцөлийн орлогод зөрүү гарч байгааг Ерөнхий инженерээс тодруулахад зарим хэрэглэгчдээс тодорхой шалтгааны улмаас техникийн нөхцөлийн хураамж авдаггүй гэсэн тайлбар өгөв.

**Аудитын илрүүлэлт:**

2015 онд 14 хэрэглэгчээс, 2016 онд 9 хэрэглэгчээс, 2017 онд 14 хэрэглэгчээс хураамж аваагүй байгаагаас харахад олгосон техникийн нөхцөлийн хураамжийн орлогыг бүрэн оруулаагүй байна.

Иймд техникийн нөхцөл авч үйл ажиллагаа явагдаж буй 12 хэрэглэгчээс 3,6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Компанийн үйл ажиллагааны бус орлогыг бүтцээр нь авч үзвэл дараах байдалтай байна.

| д/д | Орлогын зүйл                   | 2015  | 2016  | 2017 |
|-----|--------------------------------|-------|-------|------|
| 1   | Хүү алдангийн орлого           | 4,5   | 3,9   | 4,2  |
| 2   | Материал борлуулсны ашиг       | 2,3   | 0,03  | 0,2  |
| 3   | Туслах АА-н орлого             | 1,0   | 3,9   |      |
| 4   | Дэвтрийн үнэ                   | 0,04  | 1,8   |      |
| 5   | Механзмын хөлс                 | 0,8   | 5,7   | 2,7  |
| 6   | Техникийн нөхцөл               | 3,0   | 2,7   | 7,4  |
| 7   | Баримтын үнэ                   | 4,6   | 4,9   |      |
| 8   | Машины үнэ                     | 9,1   |       |      |
| 9   | Борлуулалтын хөнгөлөлт буцаалт | (2,1) | (3,2) |      |
| 10  | Тоолуурын үйлчилгээний хөлс    |       | 0,8   | 0,2  |
| 11  | СӨХ                            |       | 2,9   |      |
|     | Үндсэн бус Ү/А-ны орлогын дүн  | 23,3  | 23,4  | 14,6 |

**Аудитын илрүүлэлт:**

“Хаш гоёо” ХХК-тай хамран ажиллах гэрээ байгуулж, тус компаниар 2-р багийн төвийн төвийн ажлыг гүйцэтгүүлж санхүүжилтийн тооцоо хийхдээ төсөвт өртөгт багтсан НӨАТ-ын орлогыг суутган тооцож шилжүүлээгүй байна.

Иймд тус барилгын төсөвт өртөгт туссан 29211,9 мянган төгрөгийн НӨАТ-ыг “Хаш гоёо” ХХК-аар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**2.3. Компанийн гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс батлагдсан зардлыг баримталж ажиллаагүйгээс зарим төрлийн зардал хэтэрсэн нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна.**

Бүтэц орон тоог ТУЗ-аар батлуулан ажиллаж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

| д/д | Цалингийн хэсэг                      | 2015 он    |           | 2016 он    |           | 2017 он    |           |
|-----|--------------------------------------|------------|-----------|------------|-----------|------------|-----------|
|     |                                      | төлөвлөгөө | гүйцэтгэл | төлөвлөгөө | гүйцэтгэл | төлөвлөгөө | гүйцэтгэл |
| 1   | Захиргаа аж ахуй                     | 22         | 21        | 18         | 18        | 20         | 21        |
| 2   | Цэвэр ус, ариутгах татуурга, шуурхай | 26         | 23        | 22         | 22        | 22         | 22        |
| 3   | Дулаан хангамж                       | 32         | 27        | 28         | 28        | 3          | 3         |
| 4   | Зөөвөр                               | 3          | 3         | 4          | 4         | 28         | 27        |
|     | Дүн                                  | 83         | 74        | 72         | 71        | 73         | 73        |

Дээрх байдлаас харахад компани батлагдсан орон тоог хэтрүүлээгүй байна.

2015 онд ТУЗ-ын тогтоолоор 1398,5 сая төгрөгийн зардал баталж гүйцэтгэлээр 1214,8 сая төгрөгийн зардал, 2016 онд 894,2 сая төгрөгийн зардал баталж гүйцэтгэлээр 972,1 сая төгрөг, 2017 онд 1079,1 сая төгрөг баталж гүйцэтгэлээр 1003,5 төгрөгийн зардал гарсан байна. Үүнийг зардал тус бүрээр нь авч үзвэл: /сая төгрөг/

| үзүүлэлтүүд                         | 2015 он    |           |                         | 2016 он    |           |                         | 2017 он    |           |                         |
|-------------------------------------|------------|-----------|-------------------------|------------|-----------|-------------------------|------------|-----------|-------------------------|
|                                     | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү /хэтрэлт хэмнэлт/ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү /хэтрэлт хэмнэлт/ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү /хэтрэлт хэмнэлт/ |
| Цалин хөлс, түүнтэй адилтгах зардал | 629.3      | 578.6     | 50.7                    | 468.7      | 515.5     | -46.9                   | 599.1      | 592.0     | 7.1                     |
| Шагнал урамшуулал нийгмийн халамж   | 58.8       | 60.9      | (2.1)                   | 8.9        | 31.1      | -22.1                   | 6.3        | 9.7       | -3.4                    |
| Ашиглалтын зардал                   | 526.8      | 411.2     | 115.6                   | 284.5      | 253.4     | 31.1                    | 348.2      | 284.9     | 63.3                    |
| Бараа материалын зардал             | 65.2       | 34.4      | 30.8                    | 30.0       | 19.6      | 10.4                    | 25.6       | 35.0      | -9.3                    |
| Засварын зардал                     | 43.6       | 32.0      | 11.6                    | 36.0       | 21.3      | 14.7                    | 18.1       | 21.0      | -2.9                    |
| Бусад татвар, төлбөр хураамж        | 74.8       | 97.8      | (23.0)                  | 66.1       | 131.2     | -65.1                   | 81.7       | 60.9      | 20.8                    |
| Зардлын дүн                         | 1,398.5    | 1,214.8   | 183.6                   | 894.2      | 972.1     | -77.9                   | 1079.1     | 1003.5    | 75.6                    |

Дээрх хүснэгтээс харахад ТУЗ-өөр батлагдсан зардлыг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой зарим ангиллын батлагдсан зардлыг хэтрүүлсэн зарцуулсан байна. Тухайлбал:

**2015 онд**

- Хоол унааны хөнгөлөлт 16,8 сая төгрөгөөр хэтэрсэн нь өдрийн хоол 1000 төгрөг байсныг хамтын гэрээ хийж 3 сараас 2000 төгрөг, цэвэрлэх байгууламжийн 8 операторт олгодог унааны мөнгийг 1 гараа нь 1500 төгрөг байсныг 3000 төгрөг болгосон.
- Шуудан холбооны зардал 2,4 сая төгрөгөөр хэтэрсэн нь Интернетийн зардал төлөвлөөгүйгээс 1200,0 мянган төгрөг, гүйцэтгэх захирлын утасны төлбөр сард 70,0 мянга буюу жилд 840,0 мянгаар төлөвлөсөн боловч 1504,2 мянган төгрөг төлсөнтэй холбоотой
- Нийгмийн халамжийн зардал 1,2 сая төгрөгөөр хэтэрсэн нь Хөшөөтийн хөндийд төмс тариалж байгууллагын ажилчдад өгсөн.

#### 2016 онд

- Хоол унааны зардал 5,2 сая төгрөгөөр хэтэрсэн байгаа нь хоолны мөнгийг өдөрт 1000 төгрөг байхаар төлөвлөсөн атлаа 3000 төгрөгөөр тооцож олгосон.
- Шуудан холбооны зардал 2,7 сая хэтэрсэн байгаа нь Интернетийн зардал төлөвлөөгүйгээс 1,0 сая, гүйцэтгэх захирлын утасны төлбөр 840,0 батлагдсанаас 2484,8 мянган төгрөг төлж 1644,8 мянган төгрөг хэтрүүлэн зарцуулсан.

#### 2017 он

- Тэтгэмжийн зардал 3,4 сая төгрөг хэтэрсэн нь ТУЗ-ийн шийдвэрийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн гүйцэтгэх захиралд 6,0 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Мөн **2015 онд** эд хөрөнгийн даатгалын зардал 2,0 сая, банкны үйлчилгээний хураамж 1,7 сая, зээлийн хүүгийн зардал 15,9 сая, тэмцээн уралдааны зардал 3,4 сая, аудитын төлбөр 1,5 сая, **2016 онд** цалингийн зардал 37,2 сая, бичиг хэргийн зардал 2,7 сая, АТБӨЯХАТ-ын зардал 1,7 сая, зар сурталчилгаа 1,7 сая, даатгал 2,7 сая, зээлийн хүүгийн зардалд 17,5 сая, автомашинуудын тээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэд 1,9 сая, **2017 онд** бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 3,4 сая, материал худалдан авахад 11,5 сая, холбооны зардал 779,5 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан нь дээрх зардлуудыг төлөвлөлт хийхдээ тооцоогүйгээс шалтгаалсан байна. Тухайлбал.

**2015 онд** тэмцээн уралдааны зардал 3,4 сая төгрөгөөр хэтэрсэн нь Архангай аймагт болсон бүсийн уралдаан тэмцээний зардлыг төлөвлөөгүй, **2016 онд** Цалингийн зардал 37,2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан илүү цагийн хөлс, ээлжийн ажилтны шөнийн цагийн хөлс зэргийг дутуу тооцож төлөвлөсөн байна.

Мөн урьдчилан тооцоолох бололцоогүй, гадаад хүчин зүйлээс хамаарч дараах төлөвлөгдөөгүй зардлууд гарчээ. Үүнд:

- 2015 онд Цахилгааны зардал 14,6 сая төгрөгөөр хэтэрсэн нь цахилгааны үнэ тариф өссөн, 2016 онд Тэтгэмжийн зардал 22,1 сая төгрөгөөр хэтэрсэн нь цэвэр усны 1 слесарь ажил үүргээ гүйцэтгэж яваад нас барсан тул тэтгэмжид 23,0 сая төгрөг олгосон, Түлээ нүүрс халаалтын зардал 2,7 сая төгрөгөөр хэтэрсэн нь шинээр халаалтын зуух нэмэгдсэн, 2016 онд Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 51,9 сая төгрөг, 2017 онд Урсгал засварын зардал 2,9 сая төгрөгийн зардал хэтрүүлсэн нь төв бохирын шугам задарсан, хуучин конторын барилга нураасны улмаас клубын барилгын дулаан, бохирын холболт хийсэн Найдваргүй авлагын зардал 7,4 сая төгрөг, үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 2,5 сая төгрөгийн зардлууд тус тус гарсан байна.

Харин **2015 онд** хөдөлмөр хамгааллын зардал 12,7 сая, урсгал засварын зардал 11,5 сая, **2016 онд** цахилгааны зардал 27,7 сая, шатахууны зардал 10,7 сая, хөдөлмөр хамгааллын зардал 8,6 сая, сэлбэг материалын зардал 3,9 сая, засварын зардал 14,7 сая, баяр ёслолын зардал 5,7 сая, **2017 онд** Цахилгааны зардал 8,9 сая, түлээ нүүрс халаалт 23,0 сая, шатахууны зардал 27,0 сая, хөдөлмөр хамгааллын зардал 6,4 сая, АТБӨЯХТ-ын зардал 2,7 сая, урт хугацаат зээлийн төлбөр 15,5 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн зэргээс үзэхэд төсвийн төлөвлөлт үндэслэл муутай хийгдсэн байна.

Харин 2015 онд цалингийн зардал нь 69,9 сая, шатахууны зардал 76,0 сая төгрөгөөр хэмнэсэн нь төв уурын зуухыг 2015 онд хувьчилсантай холбоотой байна.

“Чандмань-Баянхонгор” ХК-ийн дүрмийн 7.10.2-т “Компанийн бизнес төлөвлөгөөг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих” гэж заасны дагуу ТУЗ нь компанийн бизнес төлөвлөгөөг баталж ирсэн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

Бизнес төлөвлөгөө батлуулахдаа хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2015, 2016 онд ТУЗ-ын тогтоолд хавсралтаар оруулан батлуулсан боловч батлагдаагүй хөрөнгө бэлтгэсэн, 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-ын тогтоолд тусгаагүй, батлуулаагүй байна.

Иймд цаашид Бизнес төлөвлөгөө батлахдаа хөрөнгө оруулалтын төлөвлөгөө орхигдуулахгүй баталж, хэрэгжилтэд хяналт тавих зөвлөмжийг “Чандмань-Баянхонгор”

ХК-ийн ТУЗ-ын даргад, ТУЗ-аар батлагдаагүй хөрөнгө бэлтгэхгүй байх зөвлөмжийг компанийн Гүйцэтгэх захиралд хүргүүлэв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс ногдол ашиг хуваарилах тухай” 166 тоот тогтоолын 1-т орон нутгийн өмч бүхий аж ахуйн нэгжүүд, үйлдвэрлэлийн газрын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон цэвэр ашгийг хуваарилах нормативыг тогтоожээ. Тус нормативаар нийт ашгийн 45 хувийг үйлдвэрлэлээ өргөтгөхөд, 30 хувийг ажилчдын урамшуулалд, 25 хувийг орон нутгийн хөрөнгө оруулалтын санд хуваарилахаар тогтоосон бөгөөд үүний дагуу 2015,02,17-нд ТУЗ-өөс 2014 оны ногдол ашиг 23,1 сая төгрөгийг төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байхад гүйцэтгэх захирал хэрэгжүүлээгүй байна. Иймд төвлөрүүлээгүй 23,1 сая төгрөгийг орон нутагт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоож, цаашид тогтоолыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг компанийн ТУЗ-д өгөв.

#### **Аудитын илрүүлэлт:**

*2015 онд шийдвэрлэгдээгүйгээр 19.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд: “Чандмань-Баянхонгор” ХК-ийн зүүн талд байрлах усан санг 5,6 сая төгрөгөөр, 3-р худгийн насосыг 2,1 сая төгрөгөөр, 50 жилийн ойн асрыг 1,1 сая төгрөгөөр бизнес төлөвлөгөөнд тусгалгүйгээр авсан байна.*

**2016 онд** 73,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэсэн ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээр 36,2 сая, аймгийн ИТХ-ын тогтоолоор шилжиж ирсэн зуухны 34.8 сая, тусгай зөвшөөрөл 2.0 сая, сэлбэг хэрэгслийн төлөвлөгөөний нийт 0.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл бүрэн тусгасан байна.

**2017 онд** 303,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэсэн ба үүний 90,9 сая төгрөгийн хөрөнгө нь Их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хийгдсэн хөрөнгө оруулалтаар, 66,2 сая төгрөг нь аймгийн ИТХ-ын тогтоолоор балансаас баланст шилжиж ирсэн зэрэг хөрөнгүүдийг санхүүгийн тайланд бүрэн тусгасан байна.

#### **БҮЛЭГ 3.**

Их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээг урьдчилсан төсөв, тооцоо гаргалгүй батлуулснаас батлагдсан хэмжээнээс хэтэрсэн байна.

### 3.1. Их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа элэгдлийн фонд, бусад эх үүсвэрийг тооцолгүй төлөвлөсөн байна.

Тус компани нь Их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөөг бизнес төлөвлөгөөний нэг хэсэг болгон батлуулж байгаа бөгөөд тус төлөвлөх ажлыг байгууллагын Ерөнхий инженер нэгтгэн зохион байгуулж байна. Ерөнхий инженер төлөвлөлтийг хийхдээ бүтцийн хэсэг нэгжүүдээс санал авч нэгтгэж байгаа боловч хэсгүүдээс авсан саналыг албажуулж аваагүй нь хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон эсэх нь нотлогдохгүй байна. Энэ талаар ерөнхий инженерээс тодруулахад “Хэсэг, албадын дарга нарыг цуглуулж, саналыг нь амаар авдаг, цаасаар баталгаажуулж авдаггүй” гэсэн тайлбарыг өгсөн болно. Иймд цаашид их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа хэсэг, албадаас ирүүлсэн саналыг баримтжуулан, түүнийг хэлэлцсэн хурлын тэмдэглэлийг баталгаажуулан авч архивын нэгж үүсгэж байхыг Ерөнхий инженер С.Идэрцэцэгт зөвлөв.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2015 онд 166,7 сая төгрөгөөр хөрөнгө оруулалт их засварын ажлын 6 ажлын төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлээр 110,6 сая төгрөг зарцуулсан байна. Төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

| № | Барилга объектын нэр                   | Төсөвт өртөг |                              |                        | 2016 оны<br>төлөвлөгөө | гүйцэтгэл    |
|---|----------------------------------------|--------------|------------------------------|------------------------|------------------------|--------------|
|   |                                        | Бүгд         | үүнээс<br>Барилга<br>угсралт | Тоног<br>төхөөрөм<br>ж | Өөрийн<br>хөрөнгө      |              |
| 1 | Автомашины граж                        | 25,2         | 25,2                         | 0                      | 25,2                   | 65,5         |
| 2 | Насос тоног төхөөрөмжийн өргөтгөл      | 14,1         | 7,6                          | 6,5                    | 14,1                   | 6,8          |
| 3 | Машин механизмын шинэчлэлт             | 80,0         |                              | 80,0                   | 8,0                    | 0            |
| 4 | Компьютер тоног төхөөрөмжийн шинэчлэлт | 7,4          | 0                            | 7,4                    | 7,4                    | 7,7          |
| 5 | Контроль зуухны шинэчлэлт              | 32,0         |                              | 32,0                   | 32,0                   | 30,5         |
| 6 | Хяналтын тоолуур суурилуулах           | 8,0          |                              | 8,0                    | 8,0                    |              |
|   | <b>ДҮН</b>                             | <b>166,7</b> | <b>32,8</b>                  | <b>126,9</b>           | <b>166,7</b>           | <b>110,6</b> |

#### Аудитын илрүүлэлт

Үйлчилгээний тээврийн хэрэгслүүдийн авто гражийг барихад 25.2 сая төгрөг зарцуулахаар батлуулсан байхад гүйцэтгэлээр 65.5 сая төгрөгөөр барьж ТУЗ-аар батлагдсан төсвийг 40,3 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ талаар Ерөнхий инженерээс тодруулахад “Тухайн гражийн төсөвт өртөг нь шууд зардлаар 77.7 сая төгрөгөөр тооцогдсон, тухайн онд төлөвлөгөөг батлуулахдаа

өмнө нь дулааны хэсэгт баригдсан жижиг гражийн төсвөөр батлуулсан нь алдаа гарсан байна” гэсэн тайлбар өгөв.

Дулааны зууханд нүүрс тээврийн 1 автомашиныг нэмж авахаар төлөвлөсөн байсан бөгөөд тухайн онд дулааны зуухыг хувьчлах шийдвэр гарч тухайн авто машиныг авах шаардлагагүй болсон тул хөрөнгө оруулалтад батлагдсан 80.0 сая төгрөгийн машин механизмын шинэчлэлтийн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Мөн 20 ширхэг хяналтын тоолуур шинээр суурилуулахаар төлөвлөсөн боловч тухайн ажил хэрэгжээгүй байна. Энэ талаар “Чандмань-Баянхонгор” ХК-ийн ерөнхий инженерээс тодруулахад тухайн онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ойн зурвасын хиймэл нуурын ажил болон компанийн 50 жилийн ой угтсан ажлуудыг хийж гүйцэтгэсэнтэй холбоотойгоор ажилчдын нөөц хүрэлцээгүйн улмаас тухайн ажил хэрэгжээгүй” гэсэн тайлбарыг өгөв.

Дээрх байдлаас харахад үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэлгүй өөр зүйлд компанийн санхүү, хөрөнгийн нөөцийг ашигласнаас зайлшгүй хэрэгцээ шаардлагатай ажлыг зохион байгуулалгүй орхигдуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс **2016 онд** 75.1 сая төгрөгөөр хөрөнгө оруулалт их засварын ажлын 7 ажлын төлөвлөгөөг баталсан бөгөөд гүйцэтгэлээр 36,2 сая төгрөг зарцуулсан байна. Төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

| № | Барилга объектын нэр                  | Төсөвт өртөг |                    |                    | 2016 оны<br>төлөвлөгөө | гүйцэтгэл |
|---|---------------------------------------|--------------|--------------------|--------------------|------------------------|-----------|
|   |                                       | Бүгд         | үүнээс             |                    | Өөрийн<br>хөрөнгө      |           |
|   |                                       |              | Барилга<br>угсралт | Тоног<br>төхөөрөмж |                        |           |
| 1 | Санхүү, орон сууцны программ шинэчлэх | 5.0          |                    | 5.0                | 5.0                    | 2.5       |
| 2 | Насос тоног төхөөрөмжийн шинэчлэлт    | 10.0         |                    | 10.0               | 10.0                   | 6.3       |
| 3 | Машин механизмын шинэчлэлт            | 14.0         |                    | 14.0               | 14.0                   | 12.1      |
| 4 | Багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэлт   | 8.0          | 0                  | 8.0                | 8.0                    | 8.7       |
| 5 | Контторын барилгын камержуулалт       | 3.1          |                    | 3.1                | 3.1                    | 2.2       |
| 6 | Насос тоног төхөөрөмжийн шинэчлэлт    | 5.0          |                    | 5.0                | 5.0                    | 4.5       |
| 7 | Клубын барилгын их засвар             | 30.0         | 30.0               |                    | 30.0                   |           |
|   | <b>Дүн</b>                            | 75.1         | 30.0               | 45.1               | 75.1                   | 36.2      |

Төлөвлөсөн 7 ажлаас 30.0 сая төгрөгийн клубын барилгын их засварын ажлыг хэрэгжүүлээгүй нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхээр барилга байгууламжид үзлэг хийхэд, шалны суурь шаардлага хангахгүй байсан тул засвар хийвэл үргүй зардал

гарах гээд байсан учраас ажлыг хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзэн хэрэгжүүлээгүй гэсэн тайлбарыг өгсөн.


ТУЗ-ын **2017 оны** бизнес төлөвлөгөөг батлахдаа орлого, зардал, ашиг, алдагдлыг баталсан боловч хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг батлаагүй байна.

Төлөвлөгөөнд 595,0 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг тусгасан бөгөөд үүний 250,0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн дэмжлэгээр, 345,0 сая төгрөгийг өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 310,9 сая санхүүжүүлсэн байна. Төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

| № | Барилга объектын нэр                   | Төсөвт өртөг |                 |                 | Орон нутгийн төсөв | 2016 оны төлөвлөгөө | гүйцэтгэл |
|---|----------------------------------------|--------------|-----------------|-----------------|--------------------|---------------------|-----------|
|   |                                        | Бүгд         | үүнээс          |                 |                    | Өөрийн хөрөнгө      |           |
|   |                                        |              | Барилга угсралт | Тоног төхөөрөмж |                    |                     |           |
| 1 | Шинэ оффисийн барилга                  | 500,0        | 500,0           |                 | 250,0              | 250,0               | 220,0     |
| 2 | Шинэ оффисийн тавилга шинэчлэх         | 33,0         |                 | 33,0            | 0                  | 33,0                | 33,3      |
| 3 | Машин механизмын сэлбэг, шинэчлэлт     | 5,0          |                 | 5,0             | 0                  | 5,0                 | 5,2       |
| 4 | Компьютер тоног төхөөрөмжийн шинэчлэлт | 3,0          | 0               | 3,0             | 0                  | 3,0                 | 2,7       |
| 5 | Насос тоног төхөөрөмжийн шинэчлэлт     | 4,0          |                 | 4,0             | 0                  | 4,0                 | 4,3       |
| 6 | Халаалтын зуухны шинэчлэлт             | 50,0         |                 | 50,0            | 0                  | 50,0                | 45,5      |
|   | ДҮН                                    | 595,0        | 500,0           | 95,0            | 25,0               | 345,0               | 310,9     |

Тус компани нь хөрөнгийг нөхөн сэргээх, засвар үйлчилгээ хийх, шинээр худалдан авах эх үүсвэрийг хөрөнгийн элэгдлийн зардлаар шийдвэрлэж ирсэн байна.

Аудитад хамрагдаж буй 2015-2017 оны хөрөнгө оруулалт болон эх үүсвэрийн харьцааг харуулбал:



Дээрх графикаас харахад тухайн тайлант оны элэгдлийн фондтой уялдуулахгүйгээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг гаргаж байна. 2017 онд элэгдлийн фондоос хэт их хөрөнгө оруулалт хийсэн байгаа бөгөөд энэ талаар ерөнхий нягтлан бодогчоос тодруулахад: Өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалт болон бусад зардлын хэмнэлт дансанд хуримтлагдсан үлдэгдэл болон банкнаас зээл авч эх үүсвэр бүрдүүлсэн гэсэн тайлбар өглөө. Гэвч өмнөх онуудын тооцоолол хийсэн баримт, материал, тооцоо байхгүй байна.

### 3.2. Хөрөнгө бэлтгэхдээ аудитад хамрагдсан онуудад ТБОНӨХБАҮХАТХ-ийг баримталж ажиллаагүй бөгөөд 2019 оноос худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагаанд 2015-2017 онд төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48.5-д заасан “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Энэ талаар ерөнхий нягтлан бодогчоос тодруулахад “Өмнөх онуудад худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллаагүй харин 2019 оноос эхлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллаж байгаа” гэсэн тайлбарыг өгөв.

Аудитаар “Чандмань-Баянхонгор” ХК-ийн 2015-2017 оны их засвар техник зохион байгуулалтын төлөвлөгөөг судалж үзэхэд 2015 онд хэрэгжүүлэхээр батлагдсан

төлөвлөгөөнөөс 77.7 сая төгрөгийн автомашины граж, 14.1 сая төгрөгийн насос тоног төхөөрөмжийн өргөтгөл, 32.0 сая төгрөгийн конторын зуухны шинэчлэлтийн ажил, 2016 онд машин механизмын шинэчлэлт, 2017 онд 33.0 сая төгрөгийн оффиссын тавилга шинэчлэх, халаалтын зуухны шинэчлэлийн 50.0 сая төгрөгийн ажлуудад тендер зарлаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг баримтлаагүй байна.

Тайлант онуудын худалдан авах ажиллагааг төлөвлөөгүй, зохион байгуулаагүй байгаагаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг гаргаж ажиллаагүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.5-д заасан “Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид... тайлагнана” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Иймд цаашид хөрөнгө худалдан авахдаа хөрөнгө худалдан авахдаа босго үнийг баримталж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний дагуу тендерийг зохион байгуулж, холбогдох газарт нь тайлагнаж ажиллах зөвлөмжийг “Чандмань-Баянхонгор” ХК-ийн гүйцэтгэх захиралд, түүний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг компанийн ТУЗ-д зөвлөв.

**3.3. Эд хөрөнгө бэлтгэх, данснаас хасахдаа хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлт, орлого зарлагыг бүрэн хийж бүртгэлд тусгаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.**

Аудитаар “Чандмань-Баянхонгор” ХК-ийн хөрөнгийн орлогын журналд дүн шинжилгээ хийв.

**2015 онд** 133,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэсэн ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээр 110.6 сая, төлөвлөөгүй хөрөнгө оруулалтын 19.2 сая, сэлбэг хэрэгслийн нийт 4,1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгасан байна.

**2016 онд** 73,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэсэн ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээр 36,2 сая, аймгийн ИТХ-ын тогтоолоор шилжиж ирсэн зуухны 34.8 сая, тусгай зөвшөөрлийн 2.0 сая, сэлбэг хэрэгслийн төлөвлөгөөний нийт 0.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл бүрэн тусгасан байна.

**2017 онд** 303,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэсэн ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээр 90,9 сая, аймгийн ИТХ-ын тогтоолоор балансаас баланст шилжиж ирсэн 66,2 сая, Ланд LC 76 автомашин 139,5 сая өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 7,1 сая төгрөгийн хөрөнгийг баланст бүрэн тусгасан байна

Аудитаар “Чандмань-Баянхонгор” ХК-ийн үндсэн хөрөнгийн зарлагын журналд дүн шинжилгээ хийв.

**2015 онд** нийт 99,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны № 113 дугаар тогтоолоор тус компанийн хөрөнгөнд бүртгэлтэй БНА-36-66 маркын автомашиныг актлах шийдвэр гарч 3.0 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан, ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны № 73 дугаар тогтоолоор тус компанийн хөрөнгөнд бүртгэлтэй “төв зуух”-ыг барилгын хамт худалдах шийдвэр гарч 96,4 сая төгрөгийн хөрөнгө хасагдсантай холбоотой байна.

**2016 онд** нийт 89,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны №37 дугаар тогтоолоор тус компанийн дансанд бүртгэлтэй Газ-53 автомашин, Мотоцикл, 8753,7 мянган төгрөгийн дансны үнэтэй үлдэх өртөггүй болсон цаашид ашиглагдахгүй хөрөнгүүдийг акталж, 2019,0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Терекан суудлын авто машин болон чиргүүлийг дуудлага худалдаагаар борлуулах шийдвэр гаргуулан худалдсан байна. Мөн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017.01.03-ний өдрийн № 11 дугаар тогтоолоор 55445,0 мянган төгрөгийн дансны үнэтэй, 44638,4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Лексус 470 маркын автомашиныг аймгийн Засаг даргын тамгын газарт, 6892,6 мянган төгрөгийн дансны үнэтэй 5226,9 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Хүүхдийн тоглоомын бүрдлийг Баянхонгор сумын 5-р цэцэрлэгт тус тус шилжүүлсэн байна.

**2017 онд** нийт 219,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн № 31 дүгээр тогтоолоор конторын барилгыг, ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны № 60 дугаар тогтоолоор Ковш тракторыг, ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны № 21 дүгээр тогтоолоор Хьюндай ачааны автомашин, Камаз шаланз, универсал тракторыг тус тус акталсан байна.

### **3.4. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг 2017 оноос байгуулсан хэдий ч зөвлөл нь үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу 2015-2017 оны тооллогын материалыг авч дүн шинжилгээ хийв. Тооллогын комиссын томилохдоо тушаалд хуулийн үндэслэлийг буруу авч хэрэглэсэн, комиссын бүрэлдэхүүнд тухайн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцдаг болон түүнд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтнууд болох нягтлан бодогч, нярвыг оролцуулсан байна.

2015 он, 2017 онд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12-р зүйлийн 2-д заасан “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ” 12.2.1-д заасан “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан боловч 2016 оны санхүүгийн тайлан гарахын өмнө нь хөрөнгийн тооллого хийгээгүй байгааг тодруулахад тухайн жилийн тооллогыг 2016.09.08-нд гүйцэтгэх захирлын тушаалаар хийсэн” гэх боловч энэхүү тооллого нь гүйцэтгэх захирал солигдсон буюу Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.2-д заасан “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед заавал тооллого хийнэ” гэсэн заалттай хамаарч тооллого хийгдсэн байна.

Иймд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12-р зүйлийн 2-д заасан “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана:

1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/;

2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ гэсэн заалтуудыг бүрэн хангаж ажиллах зөвлөмжийг “Чандмань-Баянхонгор” ХК-ний гүйцэтгэх захиралд зөвлөмжөөр хүргүүлэв.

Компанийн өмч хамгаалах байнгын зөвлөлийг гүйцэтгэх захирлын 2017 оны № 26 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан байна. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнд ерөнхий инженер болон ерөнхий нягтлан бодогч нар ороогүй

байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31-р зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан өмч хамгаалах Байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий ня-бо, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хуульд нийцүүлж томилох зөвлөмжийг “Чандмань-Баянхонгор” ХК-ний гүйцэтгэх захиралд зөвлөмжөөр хүргүүлэв.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 4.1-д зааснаар жилд 2-оос доошгүй удаа хуралдана гэж заасан боловч 2017 онд хуралдаагүй ямар нэгэн шийдвэр гаргаагүй байгаа нь тус журмын журмын 3-р зүйлд заасан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үүргээ хэрэгжүүлээгүй байх тул цаашид өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх захиралд зөвлөв.

#### БҮЛЭГ 4.

Компанийн үйлчилгээ, үр ашгийг сайжруулах арга хэмжээг авч ажилласнаар санхүүгийн алдагдлыг бууруулж, ашигтай ажиллах нөхцөл бололцоог хангаж ажилласан байна.

#### **4.1.Хөрөнгө оруулалтын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн ч ирээдүйд өгөх эдийн засгийн үр өгөөжийг тооцоолоогүй байна.**

Бэлтгэсэн хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг үндсэн хөрөнгийн хэмжээнд авч үзлээ.

2015 онд 133,8 сая төгрөгийн, 2016 онд 73,5 сая төгрөгийн, 2017 онд 303,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Бэлтгэсэн хөрөнгийн өнөөгийн ашиглалтын байдлын талаар хөрөнгө тус бүрээр нь ерөнхий инженерээс тодруулга авч тулган үзэхэд хэрэгцээ шаардлага бүрэн хангаж ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийн үр дүнг дараах байдлаар дүгнэж ажилласан байна. Тухайлбал:

2015 онд үйлчилгээний тээврийн хэрэгслийн гражийг шинээр барьж ашиглалтад оруулснаар өвлийн улиралд үйлчилгээний тээврийн хэрэгсэл бэлэн байдалд байснаар үйлчилгээ тасалдалгүй явах нөхцөл бололцоо бүрдсэн, Халаалтын зуухны

шинэчлэлтийг хийснээр халаалтын хүчин чадал сайжирсан гэх мэт үр дүн гарсан байна.

2016 онд Орон сууцны хэрэглэгчдийн тооцоог хийж санхүүгийн программд шууд хөрвөх зорилготой шинэ программ нэвтрүүлснээр орон сууц болон санхүүгийн программыг холбож ажлын уялдаа холбоо, санхүүгийн үнэн зөв байдал сайжирсан, Насос тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийснээр цэвэр усны эх үүсвэрийн найдвартай хэвийн ажиллагаа хангагдсан, хэрэглэгчдийн гомдол багассан, аж ахуйн хашаа болон зуухны ойр орчмыг камержуулснаар хөрөнгийн хамгаалалт, зүй бус алдагдал, нүүрсний ачилт дүүргэлтийн явцыг хяналт тавих нөхцөл бололцоо бүрдсэн зэргээр хөрөнгө оруулалтын үр ашиг гарсан байна.

2017 онд Шинэ оффиссын барилга барьж, тавилга тоног төхөөрөмж шинэчилснээр цаашид эрүүл, аюулгүй орчинд хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоо бүрдүүлсэн, халаалтын зууханд шинэчлэлт хийснээр Мэргэн худалдааны төв, шинээр баригдсан 25 айлын орон сууц, Өлзийт палас худалдаа үйлчилгээний төв зэрэг газруудыг шинээр холбож, орлого олох суурь баазыг нэмэгдүүлсэн байна.

Харин 2015 онд Лексус 470 маркын автомашинд 10,4 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал гаргаж, капиталжуулсан бөгөөд тухайн автомашиныг 2014 онд худалдан авч, 2016 онд аймгийн ЗДТГ хүсэлт тавьсны дагуу шилжүүлсэн байгаагаас харахад үр ашиггүй зардал гаргаж компанийг алдагдалтай ажиллахад гол нөлөө үзүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын үр дүнг тооцсон хэдий ч ямар хөрөнгө зарж, хэдэн төгрөгийн орлого олох эсэх, ямар үр ашиг гарах, ирээдүйд хэдэн төгрөгийн үр өгөөж авчрах эсэхийг тооцоогүй дунд хугацааны стратеги төлөвлөгөөгүй ажиллаж байна. Иймд цаашид бэлтгэх хөрөнгийн ирээдүй үр өгөөжийг тооцоолж байх зөвлөмжийг “Чандмань-Баянхонгор” ХК-д гүйцэтгэх захиралд, түүнд хяналт тавьж чиглүүлж ажиллахыг компанийн ТУЗ-д зөвлөмжөөр хүргүүлэв.

**4.2.Төсөл хөтөлбөрийн үр дүнд цэвэр усан хангамжийн үйл ажиллагаа стандартын дагуу хүртээмжтэй хэвийн явагдах нөхцөл бололцоо бүрдсэн байна.**

“Чандмань-Баянхонгор” ХК-д 2012 оноос Хот байгуулалтын салбарын МОН-23-01 төсөл хэрэгжиж эхэлсэн байна.

Тухайн төслөөр Баянхонгор хотын хэмжээнд гэр хорооллыг төвийн сүлжээнд холбох, усан хангамжийн эх үүсвэр, цэвэрлэх байгууламжийн шинэчлэлт хийх зорилготой төсөл байжээ.

Төсөл хэрэгжсэнээр үр дүнд хүрсэн зарим ажлыг талаар дурдвал:

| Төслөөр хийгдсэн ажлууд                                                                                           | Төсөл хэрэгжсэн үр дүн                                                                                                                                                                                                                  |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ундны усны эх үүсвэрийн 2 гүний худгийн барилгыг засварлах, тоног төхөөрөмжийг шинэчлэх                           | Ус хангамжийн найдвартай ажиллагаа бүрдсэн                                                                                                                                                                                              |
| Цэвэр ус нөөцлөх 1000 шоо метрийн багтаамжтай 2 сан                                                               | Баянхонгор хотод барилгажилт ихсэж, хэрэглэгч нэмэгдэж байгаатай холбогдуулан шинээр усан сангийн байгууламж ашиглалтад орсноор Хэрэглэгчдэд хүрэх усны даралт нэмэгдэж,                                                                |
| Гэр хороололд цэвэр усны 9,1 км шугам угсрах                                                                      | Гэр хороолол дундуур цэвэр усны шугам угсарснаар хэрэглэгчид эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангагдах нөхцөл бүрдсэн, гэр хороололд 3ш халуун ус ашиглалтад орсон, өрхийн эмнэлэг цэцэрлэг холбогдох боломж бүрдсэн.        |
| Гэр хороололд төвлөрсөн шугамд холбогдсон 5 ширхэг ус түгээх байр шинээр барих                                    | Гэр хорооллын усан хангамжийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах болсон.                                                                                                                                                  |
| Гэр хороололд 9 ширхэг ус түгээх байр засварлаж, цэвэр усны шугамд холбох                                         | Гэр хорооллын усан хангамжийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах болсон                                                                                                                                                   |
| Хотын төвийн 2,3 км бохир усны төв шугамыг 300 мм-ийн диаметрийн голчтой шугам угсрах                             | Бохир усны шугам сүлжээг угсарснаар 400 гаруй 3ш түрээслэгчтэй зах, худалдааны төв ариутгах татуургын шугамд холбогдож, 100 хүүхдийн цэцэрлэг, 75 албан хаагчтай 2 байгууллага, 220 айлын орон сууцны барилга шугам сүлжээнд холбогдсон |
| Бохир усны 1,8 км төв шугамыг 400 мм диаметрийн шинэчлэх                                                          | Ариутгах татуургын шугам сүлжээ нь 1995 оноос хойш ашиглагдаж байсан, одоогоор шинэчлэгдэж,                                                                                                                                             |
| Цэвэрлэх байгууламжийн шинэчлэлт /4ш, карт сэргээж, сараалжийн барилга байр барих, 2ш хэвтээ тунгаагуур хийгдсэн/ | Энгийн биологийн цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж. Цэвэрлэх байгууламж хэвийн ажилласнаар цэвэрлэгээний түвшин 75 хувьтай болж байгальд нийлүүлэгдэж байна.                                                                            |

Аудитаар зээлийн гэрээний хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтэд, зээлийн эргэн төлөлтийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийв.

Сангийн яам, Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын хооронд 2011 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 3152,6 сая төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан байна.

Тус гэрээний 2,3-д “Зээлдэгч нь дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн төлбөрийг хойшлуулах 6 жилийг оролцуулан 25 жилийн хугацаанд төлөх бөгөөд анхны төлбөрийг 2014 оноос эхлэн жил бүрийн 01 дүгээр сарын 10 болон 07 дугаар сарын 10-ны өдөр энэхүү гэрээний хавсралт 1-д заасан төлбөрийн хуваарийн дагуу Сангийн яаманд төлнө”, 3,5-д “Сангийн яам нь Зээлдэгч гуравдагч этгээдтэй дахин дамжуулан

зээлдэх гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг гагцхүү **зээлдэгчээр** төлүүлнэ”, 4,5-д “Зээлдэгч нь үндсэн болон хүүгийн төлбөр хийсэн тухай бүр Сангийн яаманд албан бичгээр мэдэгдэж улирал бүр тооцоо нийлж баталгаажуулах үүрэгтэй” гэх зэрэг заалтуудыг аймгийн ТЕЗ нь биелүүлж ажиллаагүй байна. Иймд зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, гэрээнд заасан үүргийн биелэлтийг хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**4.3. Компанийн үйлдвэрлэл үйлчилгээний өртгийг хагас бүтэн жилээр алба хэсэг бүрээр тооцож компанийн алдагдалгүй ажиллах арга хэмжээг авч ажилласнаар компанийн алдагдлыг бууруулж ажилласан байна.**

Үйлдвэрлэл үйлчилгээний өртгийг тооцохдоо цэвэр бохир усны өртгийн хэсэг нэгж тус бүрээр хуримтлуулан бүртгэж байна.

Цэвэр бохир усны үнэ тарифыг 2015, 2017 онд шинэчлэн үнэ тогтоохдоо өртгийг батлагдсан аргачлалын дагуу тооцсон байна.

Өртгийг санхүүгийн тайлан гарсан тухай бүрд нь алба хэсгээр нь зардлыг түүвэрлэж ашиг алдагдлыг тооцоолж удирдлагын шийдвэр гаргахад мэдээллээр хангаж ажилласан байна.

Аудитаар 2015-2017 оны ашгийн түвшинг хүснэгтээр харуулав.

| Үзүүлэлт                | 2015 он    |           | 2016 он    |           | 2017 он    |           |
|-------------------------|------------|-----------|------------|-----------|------------|-----------|
|                         | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| Борлуулалтын орлого     | 1,403.4    | 1,081.2   | 918.6      | 933.4     | 1,091.1    | 1,120.2   |
| нийт зардал             | 1,398.5    | 1,145.0   | 894.2      | 972.1     | 107.9      | 100.3     |
| татварын өмнөх ашиг     | 4.9        | (63.7)    | 24.4       | (38.7)    | 12.0       | 117.5     |
| Орлогын татварын зардал | 0.5        | -         | 2.4        | -         | 1.2        | 5.9       |
| Цэвэр ашиг              | 4.4        | (63.7)    | 22.0       | (38.7)    | 10.8       | 111.7     |

Компани нь 2015 онд 63,7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд алдагдалтай ажилласан шалтгаан нь тухайн онд үлдэх өртөг өндөртэй хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн гарзыг тайланд хүлээн зөвшөөрснөөс үүссэн байна. Мөн онд дулааны алба нь алдагдалтай ажиллаж байсан нь алдагдалтай ажиллах бас нэг шалтгаан болсон байна.

Иймд гүйцэтгэх удирдлагаас холбогдох түвшний шийдвэр гаргах хүмүүст хүсэлтийг уламжилж төв зуухыг хувьчилснаар цаашид алдагдалтай ажиллах нөхцөлийг зогсоосон байна.

2016 онд 38.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласны гол шалтгаан нь төлөвлөлт хийхдээ ажилчдын хуулиар нэмэгддэг нэмэгдлүүдийг тооцоогүйгээс 37,2 сая төгрөг хэтэрсэн, ажлаа гүйцэтгэж явсан нэг слесарь амь насаа алдсанаас 23,0 сая төгрөгийн төлөвлөөгүй зардал гарсан зэрэг нь нөлөөлсөн байна.

2017 онд төсөвт газруудын цэвэр бохир усны үнийг нэмэгдүүлснээр компанийн санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайжирч эхэлсэн байна.

Цэвэр усны алдагдлыг бууруулах бодит хэрэглээг тооцох зорилгоор 2015-2017 онд нийт 101 аж ахуйн нэгж байгууллага, 245 айл өрхийг тоолууржуулж ажилласан байна.

Мөн цэвэр усны алдагдал бууруулах аяныг жил бүр зарлан айл өрх болон аж ахуйн нэгж байгууллагуудын шугам сүлжээ, түүний эд ангид үзлэг хяналтыг хийж гүйцэтгэн тухай бүрд нь засварлах ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Дэлхийн усны өдөр буюу жил бүрийн 3 дугаар сарын 22-ны өдрийг тэмдэглэж цэвэр усыг хэрхэн зөв хэрэглэх, талаар сургалт зохион байгуулж сургуулийн сурагчдын дунд гар зургийн уралдаан, асуулт хариултын тэмцээн зэрэг усны зүй зохистой хэрэглээний талаар арга хэмжээ авч ажиллаж байна. Тухайлбал:

Цэвэр усны хомсдол, үнэ цэнэ сэдэвт сургалтыг аймгийн төвийн байгууллагуудад зохион байгуулж ажилласан байна. Мөн байгаль орчинд нөлөөлөх үнэлгээг хийлгэж ажилласан байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

Усны алдагдлыг бууруулах дээрх арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа боловч бодит байдалд усны алдагдал жил ирэх тусам өсөх үзүүлэлттэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

| д/д | үзүүлэлт               | 2015     | 2016     | 2017     |
|-----|------------------------|----------|----------|----------|
| 1   | Нийт олборлосон ус     | 678685.5 | 678141.6 | 758717.0 |
| 2   | нийт түгээсэн ус       | 418771.0 | 398885.0 | 355002.6 |
| 3   | Усны алдагдал /м3/     | 259914.5 | 279256.6 | 403714.4 |
| 4   | Усны алдагдал /хувиар/ | 38.3     | 41.2     | 53.2     |

Усны алдагдлын талаар Ерөнхий инженерээс тодруулахад “Ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгийн насосны зарцуулалтыг насосны бүрэн хүчин чадлаар тооцож байгаа учраас 2015 онд 678686м<sup>3</sup>, 2016 онд 646707м<sup>3</sup>, 2017 онд 758717м<sup>3</sup> ус түгээсэнээр тайланд тусгасан ба насосны бүтээлийн 80 хувиар тооцож үзэхэд 2015 онд 623233м<sup>3</sup>, 2016 онд 612000м<sup>3</sup>, 2017 онд 673000 м<sup>3</sup> ус олборлосон байна” гэсэн тайлбар өгсөн боловч зохицуулах зөвлөлд гаргаж өгсөн тайланд 80 хувиар тооцоогүй байна.

Иймд цаашид усны алдагдлыг тодорхойлж, хяналтын тоолуурыг байршуулан усны алдагдал бууруулах, шахсан усны мөнгийг бүрэн цуглуулах арга хэмжээ авч ажиллахыг компанийн гүйцэтгэх удирдлагад зөвлөв.

Аудитаар нийт 398,2 сая төгрөгийн зөрчил илэрч 55,5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, компанийн үйл ажиллагааг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, 342,7 сая төгрөгийн зөрчил давтан гаргахгүй байх 15 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. “Чандмань-Баянхонгор” ХК нь хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэр гарч, дүрмийг өөрчлөн улсын бүртгэлд бүртгүүлсэн хэдий ч хуульд заасан шаардлагын дагуу үнэт цаасаа бүртгүүлээгүй, компанийн дүрмийг баримталж ажиллаагүй байна.

2. Хуулийн дагуу усны эх үүсвэр болон дахин дамжуулах байгууламжийн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй байна.

3. Компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа үндэслэл муутай төлөвлөснөөс орлогын төлөвлөгөө тасрах, батлагдаагүй зардал гаргасан нь алдагдалтай ажиллах шалтгаан болсон байна.

4. Их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа элэгдлийн фонд, бусад эх үүсвэрийг тооцолгүй төлөвлөсөн байна.

5. Борлуулалтын орлогыг тайлагнахдаа зарим орлогыг орхигдуулж тайлагнасан байна.

6. Хөрөнгө бэлтгэхдээ аудитад хамрагдсан онуудад ТБОНӨХБАҮХАТХ-ийг баримталж ажиллаагүй бөгөөд 2019 оноос худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна

7. Эд хөрөнгө бэлтгэх, данснаас хасахдаа хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлт, орлого зарлагыг бүрэн хийж бүртгэлд тусгаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

8. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг 2017 оноос байгуулсан хэдий ч зөвлөл нь үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

9. Төсөл хөтөлбөрийн үр дүнд цэвэр усан хангамжийн үйл ажиллагаа стандартын дагуу хүртээмжтэй хэвийн явагдах нөхцөл бололцоо бүрдсэн байна.

10. Компанийн үйлдвэрлэл үйлчилгээний өртгийг хагас бүтэн жилээр алба хэсэг бүрээр тооцож компанийн алдагдалгүй ажиллах арга хэмжээг авч ажилласнаар компанийн алдагдлыг бууруулж ажилласан байна.

11. Усны алдагдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч усны хяналтын тоолуургүйгээс усны алдагдлыг бодитой тооцоогүй байна.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### Нэг.Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа:

1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-д “нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

2. ТУЗ-ийн гишүүдийг компанийн тухай хуулийн 75.4 дэх заалтад нийцүүлж хараат бус гишүүний тоог зохих хэмжээнд хүргэж байгуулах.

### Хоёр. Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа:

1. Азийн хөгжлийн банкнаас авсан зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, гэрээнд заасан үүргийн биелэлтийг хангаж ажиллах.

2. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Улсын онц чухал объектод хамаарах ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг дотоодын цэрэг гүйцэтгэж, бусад ус хангамжийн эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байна” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

### Гурав.”Чандмань Баянхонгор” ХК-ийн ТУЗ-ын дарга П.Рэнцэнпэлжээ танаа:

1. Бизнес төлөвлөгөө батлахдаа хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг орхигдуулахгүй баталж, хэрэгжилтэд хяналт тавих үүргээ хэрэгжүүлж Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэж байх.

2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс ногдол ашиг хуваарилах тухай” 166 тоот тогтоолыг хэрэгжүүлж ажиллах

3. Их засвар, техник зохион байгуулалтын хөрөнгө оруулалтаар бэлтгэж буй хөрөнгийн ирээдүй үр өгөөжийг тооцоолсон эсэхэд хяналт тавьж ач холбогдлоор нь эрэмбэлж баталж байх.

**Дөрөв.”Чандмань Баянхонгор” ХК –ийн гүйцэтгэх захирал Э.Энхбат танаа:**

1. Үнэт цаасыг хуулийн дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлж, Компанийн үйл ажиллагааг дүрмийн дагуу явуулж, хуулийн зөрчлийг арилгах.
  2. Санхүүгийн төлөвлөгөөг боловсруулахдаа нэр төрлөөр нь бодитой, үнэн зөв, уялдаа холбоотой төлөвлөж байх.
  3. Хэрэглэгчидээс авах борлуулалтын орлогыг бодит тоо хэмжээнд үндэслэн үнэн зөв тайлагнаж байх.
  4. ТУЗ-аар батлагдаагүй хөрөнгө бэлтгэх, зардлыг хэтрүүлэн зарцуулдаг байдлыг зогсоох.
  5. Хөрөнгө худалдан авахдаа хөрөнгө худалдан авахдаа босго үнийг баримталж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний дагуу тендерийг зохион байгуулж, холбогдох газарт нь тайлагнаж ажиллах.
  6. Өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хуульд нийцүүлж томилох.
  7. Цаашид бэлтгэх хөрөнгийн ирээдүй үр өгөөжийг тооцоолж байх.
  8. Хяналтын тоолуур байршуулан, усны алдагдлыг тодорхойлж, алдагдлыг бууруулах, шахсан усыг төлбөрийг бүрэн цуглуулах арга хэмжээ авч ажиллах.
- Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2019 оны 11 дугаар сарын 25-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.